НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

ЧС Чухал Сэдэв
БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2026 ОНЫ 11 ДҮГЭЭР САР

МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮДИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Д.Лхамсүрэн[1]

Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөлд нийт 815 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ тусгагдсанаас 318 нь шинээр хэрэгжих, 497 нь өмнөх онуудаас үргэлжлэх төсөл юм. Энэхүү судалгаагаар шинэ 318 төслийн бүтэц, төрөл, төсөвт өртөг, санхүүжилтийг шинжиллээ. Мөн ижил хүчин чадалтай төслүүдийн өртөг, санхүүжилтийн зөрүү, эхний жилийн санхүүжилт Төсвийн тухай хуульд нийцэж буй эсэх, төслүүд тулгамдсан хэрэгцээтэй хэрхэн уялдаж байгааг нягтлав. Түүнчлэн 2027 оны төсөвт туссан хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөвт өртөг өмнөх оны төлөвлөлтөөс хэр зэрэг өөрчлөгдсөнийг судаллаа.


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНЭ ТӨСЛИЙН БҮТЭЦ, ӨРТӨГ

Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд нийт 5.45 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 318 шинэ төсөл, арга хэмжээ тусгагдаж, 2027 онд 3.22 их наяд төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөжээ.

Шинэ 318 төслийн 266 нь барилга байгууламжийн төсөл бөгөөд тэдгээрийн төсөвт өртөг 4.94 их наяд төгрөг буюу хөрөнгө оруулалтын нийт өртгийн 90 хувийг эзэлнэ. Үлдсэн 52 төсөл нь тоног төхөөрөмжийн 32, их засварын 16, техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулах хоёр, цахим системийн хоёр төслөөс бүрдэнэ.

[1] Талархал: Энэхүү дүн шинжилгээг сайжруулах зорилгоор үнэтэй санал, шүүмж өгсөн Нээлттэй Нийгэм форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадамд талархал илэрхийлж байна.

Зураг 1. 2027 оны төсвийн хөрөнгө оруулалтын нийт төсөвт өртгийн 24 хувь нь боловсролын салбарт ногдоно



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Тайлбар: Зураг 1-д төслүүдийг нэр, төрөлд нь үндэслэн салбараар ангилсан. Харин Хүснэгт 1-д санхүүжилтийг нь хариуцах сайдаар (төсвийн ерөнхийлөн захирагчаар) бүлэглэсэн. Нэг сайдын багцад хэд хэдэн салбарын төсөл багтаж болох тул эдгээр ангиллын төслийн тоо хоорондоо ялгаатай байна. Жишээ нь Боловсролын сайдын 93 төслийн 89 нь боловсролын, хоёр нь спортын, нэг нь нийгмийн хамгааллын, нэг нь (сургалтын орчин, тоног төхөөрөмжийн хүртээмжийг сайжруулах төсөл, 75 тэрбум төгрөг) Зураг 1-ийн "Тоног төхөөрөмж, ТЭЗҮ, цахим систем, бусад" ангилалд орсон. Эдгээр 93 төсөл бүгд Боловсролын сайдын багцад байгаа.

Шинэ төслүүдийн нийт төсөвт өртгийн 70 хувь нь боловсрол, зам, тээвэр, эрчим хүчний салбарт ногдож байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаар (төсвийг хуваарилж, зарцуулалтыг хариуцдаг сайд, байгууллагын дарга) авч үзвэл шинэ хөрөнгө оруулалтын 69.5 хувь нь Боловсролын сайд, Эрчим хүчний сайд, Зам, тээврийн сайдын багцад төвлөрсөн байна.

Соёлын салбарт нийт 114.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 шинэ төсөл бий. Хамгийн өндөр төсөвт өртөгтэй нь Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын угсаатны зүйн музей (35.4 тэрбум төгрөг, "Оюу толгой" ХХК-ийн ногдол ашгаас), Булган аймгийн хөгжимт жүжгийн театр (22 тэрбум төгрөг), Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн соёлын ордныг буулгаж шинээр барих төсөл (21 тэрбум төгрөг) юм. Бусад нь соёлын өв болон салбарын барилгын их засвар (улсын хэмжээнд, 11.3 тэрбум төгрөг), Өмнөговь, Увс аймгийн гурван сумын соёлын төв (5.0–7.3 тэрбум төгрөг), Дорнод, Говьсүмбэр, Орхон аймгийн гурван барилгын дуусгал (1.4–3.4 тэрбум төгрөг) юм. Орон сууцны салбарт дөрвөн төсөл бий. Үүнд: Зэвсэгт хүчний ангийн 40 айлын орон сууц (Хангайн бүс, штабын барилгын хамт 11 тэрбум төгрөг; Зүүн бүс, 6.5 тэрбум төгрөг), Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 48 айлын орон сууцны үлдэгдэл санхүүжилт (7 тэрбум төгрөг), Дорнод аймгийн Халхгол сумын хилийн цэргийн ангийн 20 айлын орон сууцны их засвар (1.7 тэрбум төгрөг) тус тус байна.

Хүснэгт 1. Монгол Улсын 2027 оны төсвөөс хамгийн өндөр төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын шинэ төслүүд хэрэгжүүлэх 5 төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төслийн тоо	Өртөг, тэрбум төгрөг	Нийт төсөвт өртөгт эзлэх хувь
Боловсролын сайд	93	1,424.0	26.1%
Эрчим хүчний сайд	29	1,217.1	22.3%
Зам, тээврийн сайд	49	1,149.3	21.1%
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	24	308.7	5.7%
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	21	302.3	5.5%

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Шинэ хэрэгжих 318 төслийн 51 нь "Оюу толгой" ХХК-ийн ногдол ашгаас, 267 нь улсын төсвөөс санхүүжнэ. "Оюу толгой" ХХК-ийн ногдол ашгаас санхүүжих төслүүд тоогоороо цөөн (16 хувь) боловч 2027 оны шинэ хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 61 хувийг эзэлнэ. Учир нь эдгээр төсөлд 2027 онд нийт өртгийнх нь 85 хувьтай тэнцэх санхүүжилт төлөвлөсөн бол улсын төсвийн төслүүдэд 40 хувийг төлөвлөжээ.


Хүснэгт 2. Монгол Улсын 2027 оны хөрөнгө оруулалтын шинэ төслүүд, санхүүжилтийн эх үүсвэрээр

Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөл	Нийт өртөг, их наяд төгрөг	2027 онд санхүүжих, их наяд төгрөг	2027 оны санхүүжилтэд эзлэх хувь
"Оюу толгой" ХХК-ийн ногдол ашиг	51	2.32	1.96	61%
Улсын төсөв	267	3.13	1.25	39%
Нийт	318	5.45	3.22	100%

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Тайлбар: Дүнг тоймлосон тул мөрүүдийн нийлбэр нийт дүнгээс 0.01 их наяд төгрөгөөр зөрж болно.

Зураг 2. 2027 оны шинэ хөрөнгө оруулалтын төсөвт өртгийн дүнгээр Улаанбаатар хот тэргүүлж байна



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Тайлбар: Байршлыг тодорхой заагаагүй буюу "Улсын хэмжээнд", "Бүсийн хэмжээнд", олон аймгийг хамарсан болон гадаадад хэрэгжих 1.1 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 40 төсөл дээрх тооцоонд ороогүй болно. Эдгээр нь улсын хэмжээнд 20, бүсийн хэмжээнд 10, олон аймагт найм, гадаадад хоёр төсөл юм. Хамгийн өндөр төсөвт өртөгтэй 5 төсөл нь "Ногоон, ухаалаг сургууль" төсөл (улсын хэмжээнд, 240.7 тэрбум төгрөг), боловсролын салбарын сургалтын орчин, тоног төхөөрөмжийн төсөл (улсын хэмжээнд, 75 тэрбум төгрөг), Жаргалант – Шинэ-Идэр – Мөрөн чиглэлийн авто зам (Хойд бүс, 61 тэрбум төгрөг), Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн инженерийн дэд бүтэц, үерийн далан (52.8 тэрбум төгрөг), эрүүл мэндийн тоног төхөөрөмж (улсын хэмжээнд, 50 тэрбум төгрөг) юм. Жагсаалтыг Хавсралт 1-д харуулав.

Улаанбаатар хотод нийт 1.28 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 66 шинэ төсөл хэрэгжихээр төлөвлөсөн нь шинэ төслүүдийн нийт төсөвт өртгийн 23 хувийг эзэлж байна. Хамгийн өндөр төсөвт өртөгтэй таван төсөл нь Дулааны цахилгаан станц VI-ийн 300 МВт-ын хөрөнгө оруулалт (400 тэрбум төгрөг, "Оюу толгой" ХХК-ийн ногдол ашгаас), Баянгол, Хан-Уул дүүргийн боловсролын хүртээмжийг сайжруулах төсөл (70 тэрбум төгрөг), Чингэлтэй дүүргийн хүүхдийн зуслангийн барилга (46 тэрбум төгрөг), тусгай зориулалтын төвийн барилгын дуусгал (39.7 тэрбум төгрөг), Сүхбаатар дүүргийн гамшгаас хамгаалах нэгдсэн удирдлагын штабын барилга (39.3 тэрбум төгрөг) бөгөөд эдгээр нь нийслэлийн шинэ төслийн өртгийн 46 хувийг эзэлнэ. Аймаг бүрд доод тал нь нэг шинэ төсөл хэрэгжихээр байна. Төсвийн хавсралтад аймаг бүрд ногдох өртгийг заагаагүй тул олон аймагт хэрэгжих төслийн өртгийг аймгуудад хуваагаагүй.

ИЖИЛ ХҮЧИН ЧАДАЛТАЙ ТӨСЛҮҮДИЙН ТӨСӨВТ ӨРТӨГ


Ижил төрөл, ижил хүчин чадалтай барилгын төсөвт өртөг 170 хүртэл хувиар зөрүүтэй байна.

Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд туссан шинэ барилгын төслүүдээс төрөл, хүчин чадлаар нь харьцуулах боломжтой 52 төслийг 10 бүлэгт ангилав. Энд төрөл, хүчин чадал нь ижил барилгын төслүүдийг нэг бүлэгт хамруулсан. Тухайлбал, 640 суудалтай сургуулийн барилгууд нэг бүлэг болно. Төсөвт өртгийн хамгийн их зөрүү 640 суудалтай сургуульд байгаа бөгөөд хамгийн өндөр төсөвт өртөгтэй сургуулийн барилга нь хамгийн бага өртөгтэйгөөсөө 170 хувиар өндөр байна.

Тухайлбал, 640 суудалтай сургуулиудаас хамгийн бага төсөвт өртөгтэй нь Сэлэнгэ аймгийн Баянгол сумын сургуулийн барилга (8.6 тэрбум төгрөг), хамгийн өндөр нь Ховд аймгийн Булган сум болон Улаанбаатар хотын Баянгол дүүргийн “Шинэ эхлэл” олон улсын хөтөлбөртэй сургуулийн барилга (тус бүр 23 тэрбум төгрөг) байна. Цэцэрлэгийн хувьд 100 ортой цэцэрлэгийн барилга Баянхонгор аймгийн Эрдэнэцогт суманд 3.3 тэрбум төгрөг, Дорнод аймгийн Баян-Уул суманд 6.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй байна. Бүлэг бүрийн хамгийн бага болон их өртөгтэй төслийн байршлыг Зураг 3-т, бүх 52 төслийг Хавсралт 3-т харуулав.

960 суудалтай сургуулиудаас хамгийн бага төсөвт өртөгтэй нь Архангай аймгийн Эрдэнэбулган сумын сургуулийн барилга (24.6 тэрбум төгрөг), хамгийн их төсөвт өртөгтэй нь Улаанбаатар хотын Багануур дүүргийн сургуулийн барилга (32.4 тэрбум төгрөг) бөгөөд зөрүү нь 32 хувь байна. Харин 100 ортой дотуур байрнаас хамгийн бага төсөвт өртөгтэй нь Завхан аймгийн Идэр сумын дотуур байр (3.1 тэрбум төгрөг), хамгийн өндөр нь Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын дотуур байр (5.6 тэрбум төгрөг) бөгөөд зөрүү нь 80 хувь тус тус байна.

Зураг 3. 2027 оны төсөвт туссан ижил төрлийн барилгын төсөвт өртгийн харьцуулалт (тэрбум төгрөг): 640 суудалтай сургуулийн төсөвт өртөг 170 хувиар зөрүүтэй байна




Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Тайлбар: Хамгийн бага, хамгийн өндөр төсөвт өртөгтэй төслийн байршлыг утгын хажууд хаалтад бичив.

Байршлын нөлөөг харахын тулд төслүүдийг Улаанбаатар, аймгийн төв, сум гэсэн гурван төрөлд хувааж харьцуулсан. Нэг төрлийн байршилд, тухайлбал сумдад баригдах 640 суудалтай сургуулиудын хооронд ч төсөвт өртөг 2.7 дахин хүртэл зөрүүтэй тул үүнийг зөвхөн байршлаар тайлбарлах боломжгүй байна. Судалгаанд нийслэлээс алслагдсан зайн мэдээлэл ороогүй тул 640 суудалтай долоон сургуулийн өртгийг байршлаар нь харьцуулахад: Улаанбаатарт 21.6 ба 23 тэрбум төгрөг, баруун бүсийн гурван суманд 17.5–23.0 тэрбум төгрөг, Өвөрхангай аймгийн Арвайхээрд 21.6 тэрбум төгрөг, Сэлэнгэ аймгийн Баянгол суманд 8.6 тэрбум төгрөг байна. Ийм цөөн жишээнээс Улаанбаатараас алслагдсан байдлын нөлөөг дүгнэх боломжгүй юм.

Зураг 4. Ижил төрлийн байршилд ч ижил барилгын төсөвт өртөг 2.7 дахин хүртэл зөрүүтэй байна



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Тайлбар: Байршлын төрөл нь Улаанбаатар, аймгийн төв, сум. Цэг бүр нэг төсөл; ижил өртөгтэй төслүүдийн цэг давхацна (жишээ нь 300 ортой 15 дотуур байр тус бүр 17.1 тэрбум төгрөг). Харьцуулалтад хамрагдсан төслийн тоо цөөн тул төсөвт өртөгт байршлын үзүүлэх нөлөөг тооцоогүй.

ИЖИЛ ХҮЧИН ЧАДАЛТАЙ ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ

Ижил хүчин чадалтай барилгын ихэнх нь эхний жилдээ өртгийнхөө 30–45 хувьтай тэнцэх санхүүжилт авах бол 300 ортой 15 дотуур байр нэг жилд бүрэн санхүүжнэ.

Ижил хүчин чадалтай барилгуудад 2027 онд олгох санхүүжилтийн дүн мөн ялгаатай байна. Доорх хүснэгтийн медиан гэдэг нь бүлгийн төслүүдийг дүнгээр нь эрэмбэлэхэд голд орох утга (тэгш тоотой бол голын хоёрын дундаж) юм. Харьцуулалтад хамрагдсан 52 төслөөс 2027 онд хамгийн бага санхүүжилт олгохоор төлөвлөсөн таван төсөл нь Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын 100 ортой дотуур байр (1.3 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн 23 хувь), Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын 100 ортой цэцэрлэг (1.3 тэрбум төгрөг, 40 хувь), Завхан аймгийн Идэр сумын 100 ортой дотуур байр (1.6 тэрбум төгрөг, 51 хувь), Увс аймгийн Түргэн сумын 10 ортой эрүүл мэндийн төв (1.7 тэрбум төгрөг, 40 хувь), Дорнод аймгийн Чулуунхороот сумын 100 ортой цэцэрлэг (1.8 тэрбум төгрөг, 40 хувь) бол хамгийн их нь 300 ортой 15 дотуур байр (тус бүр 17.1 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн 100 хувь, жишээ нь Төв аймгийн Зуунмод сумын олон улсын хөтөлбөртэй төрөлжсөн ахлах сургуулийн дотуур байр) юм.

Хүснэгт 3. Ижил хүчин чадалтай бүлгийн төслүүдэд 2027 онд олгох санхүүжилтийн дүн

Бүлэг	Төсөл	2027 онд санхүүжих, тэрбум төгрөг (хамгийн бага–хамгийн их)	Эхний жилийн санхүүжилт өртөгт эзлэх хувь (медиан)
Сургууль, 320 суудал	8	3.0–5.9	30%
Сургууль, 640 суудал	7	2.6–6.9	30%
Сургууль, 960 суудал	5	5.3–9.7	21%
Цэцэрлэг, 100 ор	3	1.3–2.6	40%
Цэцэрлэг, 150 ор	4	2.2–2.9	40%
Цэцэрлэг, 200 ор	2	2.8–3.0	40%
Цэцэрлэг, 240 ор	2	2.3–3.1	35%
Дотуур байр, 100 ор	4	1.3–2.3	45%
Дотуур байр, 300 ор	15	бүгд 17.1	100%
Эрүүл мэндийн төв (сум), 10 ор	2	1.7–2.2	40%

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо


Төсөл бүрт олгох санхүүжилтийг Хавсралт 3-т харуулав.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНЭ ТӨСЛҮҮДИЙН ЭХНИЙ ЖИЛИЙН САНХҮҮЖИЛТ БА ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 29.3.5 ДАХЬ ЗААЛТ

Улсын төсвөөр санхүүжих барилга байгууламжийн 218 шинэ төслийн 180 нь эхний жилдээ Төсвийн тухай хуулийн 29.3.5 дахь заалтад заасан хэмжээнээс бага санхүүжилттэй байна.

Төсвийн тухай хуулийн 29.3.5 дахь заалтаар шинээр эхлэх барилга байгууламжийн эхний жилийн санхүүжилт нь төсөвт өртгийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваасан хэмжээнээс багагүй байх ёстой. Иймд хоёр жил хэрэгжих төсөлд төсөвт өртгийн 50 хувь, гурван жил хэрэгжих төсөлд 33 хувьтай тэнцэх санхүүжилт олгох шаардлагатай. Гэвч 2027 оны төсөвт хоёр жил хэрэгжих төслүүдэд нийт өртгийнх нь 41 хувийг, гурван жил хэрэгжих төслүүдэд 27 хувийг олгохоор төлөвлөжээ. Эхний жилийн санхүүжилтийг хоёр байдлаар нягтлав. Нэгдүгээрт, хоёр ба гурван жил хэрэгжих 207 төслийн 196-д нь 2027 оны санхүүжилт төсөвт өртгийг жилд тэнцүү хуваасан хэмжээнээс бага байна. Энэ харьцуулалт нь санхүүжилтийн хэмжээг тооцсон үр дүн бөгөөд хуулийн шаардлага хангасан эсэхийг тогтоосон дүгнэлт биш юм. Хоёрдугаарт, хуулийн заалт хамаарах нь эргэлзээгүй, улсын төсвөөр санхүүжих барилга байгууламжийн 218 төслийг хуулийн шаардлагад нийцэж буй эсэхийг шалгахад 180 төсөл уг шаардлагыг хангаагүй байна.

Зураг 5. Хоёр ба түүнээс дээш жил хэрэгжих төслүүдийн эхний жилийн санхүүжилт: 207 төслийн 196-д тэнцүү хуваасан хэмжээнээс бага санхүүжилт тусгажээ



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо


Тайлбар: Хоёр жилийн хугацаанд хэрэгжих 113 төслийн 102-т, гурван жилд хэрэгжих 94 төслийн бүгдэд нь тэнцүү хуваасан хэмжээнээс бага санхүүжилт тусгасан байна. Зураг үзүүлсэн хувь нь 2027 оны санхүүжилтийн төсөвт өртөгт эзлэх хувийг илэрхийлнэ.

Хоёр ба түүнээс дээш жил хэрэгжих 207 төслийн 196-д 2027 онд олгохоор төлөвлөсөн санхүүжилт нь өртгийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваасан хэмжээнээс нийлбэрээрээ 224.1 тэрбум төгрөгөөр бага байна.

Эхний жилийн санхүүжилт болон төсөвт өртгийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваасан дүнгийн зөрүү хамгийн их байгаа 10 төсөл бүгд улсын төсвөөр санхүүжих барилга байгууламж байна. Үүнд:

- Төв аймгийн Бүрэн сум чиглэлийн 50 км авто замын эхлэл (өртөг 86.8 тэрбум төгрөг; эхний жилд 17.4 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн 20 хувь; дутуу 11.6 тэрбум төгрөг)
- Ховд аймгийн Жаргалант сумын хүүхэд, залуучуудын спортын цогцолбор (өртөг 70.0 тэрбум төгрөг; эхний жилд 15.0 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн 21 хувь; дутуу 8.3 тэрбум төгрөг)
- Хэнтий аймгийн Норовлин – Дадал чиглэлийн хатуу хучилттай авто зам (өртөг 49.3 тэрбум төгрөг; эхний жилд 9.9 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн 20 хувь; дутуу 6.6 тэрбум төгрөг)
- Ховд – Улаангом чиглэлийн замаас Өмнөговь сум чиглэлийн 25.4 км авто зам (өртөг 38.4 тэрбум төгрөг; эхний жилд 7.7 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн 20 хувь; дутуу 5.1 тэрбум төгрөг)
- Увс, Ховд, Дорнод аймгийн хүүхэд, залуучуудын хөлбөмбөгийн битүү талбай (өртөг 42.0 тэрбум төгрөг; эхний жилд 16.0 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн 38 хувь; дутуу 5.0 тэрбум төгрөг)
- Улаанбаатар хотын Баянгол, Хан-Уул дүүргийн боловсролын хүртээмжийг сайжруулах төсөл (өртөг 70.0 тэрбум төгрөг; эхний жилд 30.2 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн 43 хувь; дутуу 4.8 тэрбум төгрөг)
- Төв аймгийн Өндөрширээт сумын төв хүртэлх 27.2 км авто зам (өртөг 36.0 тэрбум төгрөг; эхний жилд 7.2 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн 20 хувь; дутуу 4.8 тэрбум төгрөг)
- Дархан-Уул аймгийн Дархан сумын Шинэ, Хуучин Дарханыг холбосон авто замын 2 дугаар үе шат (өртөг 32.6 тэрбум төгрөг; эхний жилд 6.5 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн 20 хувь; дутуу 4.3 тэрбум төгрөг)
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын мэргэжлийн боловсролын сургууль, дотуур байр (өртөг 29.1 тэрбум төгрөг; эхний жилд 5.8 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн 20 хувь; дутуу 3.9 тэрбум төгрөг)
- Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн хүүхдийн зуслангийн барилга (өртөг 46.0 тэрбум төгрөг; эхний жилд 11.5 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн 25 хувь; дутуу 3.8 тэрбум төгрөг)

Зураг 6. Хэрэгжих хугацаанд тэнцүү хуваасан хэмжээнээс хамгийн их дутуу санхүүжилттэй 10 төсөлд 2027 онд төсөвт өртгийн 20–43 хувийг олгохоор төлөвлөжээ



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Энэхүү судалгаагаар 29.3.5 дахь заалт хамаарах нь эргэлзээгүй, улсын төсвөөр санхүүжих барилга байгууламжийн 218 төслийг шалгалаа. Бусад 100 төсөлд тоног төхөөрөмжийн 32, их засварын 16, ТЭЗҮ болон цахим системийн дөрөв, "Оюу толгой" ХХК-ийн ногдол ашгаас санхүүжих барилга байгууламжийн 48 төсөл тус тус орно. Тоног төхөөрөмж, их засварын санхүүжилтийг хуулийн 29.3.3-т тусад нь зохицуулсан. ТЭЗҮ, цахим систем нь барилга байгууламж биш. "Оюу толгой" ХХК-ийн ногдол ашгаас санхүүжих төсөлд уг заалт хамаарах эсэх талаар албан ёсны тайлбар олдоогүй. Иймд эдгээр 100 төсөлд хуулийн дүгнэлт гаргаагүй болно.

Хүснэгт 4. Төсвийн тухай хуулийн 29.3.5 дахь заалтын шаардлагад нийцсэн байдал

Үзүүлэлт	Төслийн тоо
Хуулийн шаардлага хангасан	38
Хуулийн шаардлага хангаагүй (эхний жилд тэнцүү хэмжээнээс бага)	180

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), Төсвийн тухай хууль, судлаачийн тооцоо

Хуулийн шаардлага хангаагүй 180 төслийн жагсаалтыг Хавсралт 2-т харуулав.


ШИНЭ БАРИЛГЫН ТӨСӨВТ ӨРТГИЙГ ӨМНӨХ ЖИЛҮҮДТЭЙ ХАРЬЦУУЛСАН НЬ

Ижил төрөл, хүчин чадалтай барилгын 2027 оны төсөвт өртөг 2026 оны батлагдсан төсөвт туссан төслүүдийнхээс ойролцоогоор 55 хувиар, барилгын үнийн нэг жилийн өсөлтөөр тохируулахад ч ойролцоогоор 40 хувиар өндөр байна.

Жишээ нь 320 суудалтай сургуулийн медиан өртөг 2026 оны батлагдсан жагсаалтад 7.8 тэрбум төгрөг байсан бол 2027 оны шинэ төслүүдэд 14 тэрбум төгрөг байна. Медиан өртөг гэдэг нь бүлгийн төслүүдийг өртгөөр нь эрэмбэлэхэд голд орох төслийн өртөг юм.

Тухайлбал, 960 суудалтай сургуулийн өртөг 2026 оны батлагдсан жагсаалтад Орхон аймгийн Баян-Өндөр суманд 14.9 тэрбум төгрөг байсан бол 2027 оны төсвийн төсөлд Архангай аймгийн Эрдэнэбулган суманд 24.6 тэрбум төгрөг байна. Мөн 640 суудалтай сургуулийн хувьд Дорнод аймгийн Хэрлэн суманд 2026 оны төсөвт өртөг 12.9 тэрбум төгрөг, Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд 2027 оны төсөвт өртөг 21.6 тэрбум төгрөг, 150 ортой цэцэрлэгийн хувьд Завхан аймгийн Улиастай суманд 2026 оны төсөвт өртөг 4.8 тэрбум төгрөг, Булган аймгийн Булган суманд 2027 оны төсөвт өртөг 7.3 тэрбум төгрөг байна. Эдгээр барилга бүгд аймгийн төвд баригдахаар төлөвлөгдсөн. Харин Говь-Алтай аймгийн Дарви сумын 100 ортой дотуур байрны 2027 оны өртөг 4.6 тэрбум төгрөг байгаа нь 2026 оны жагсаалтад туссан мөн аймгийн Цээл сумын ижил хүчин чадалтай дотуур байрныхтай адил байна.

Зураг 7. 2027 оны шинэ барилгуудын төсөвт өртөг 2026 оны батлагдсан жагсаалтын ижил барилгынхтай харьцуулахад 15–86 хувиар өндөр байна



Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль (2 дугаар хавсралт), Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Тайлбар: Харьцуулалтыг 2026 оны батлагдсан төсөв болон 2027 оны төсвийн төсөлд туссан төслүүдийн медиан төсөвт өртөгт үндэслэн, нэрлэсэн үнээр хийсэн. Бүлэг бүрийн 2027 ба 2026 оны төслийн тоог хаалтад харуулав. Бүлэг тус бүрийн медиан өртөг, үнийн өсөлтийг хассан харьцааг Хавсралт 4-т харуулав.

Төсвийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад инфляцыг 2026 онд дунджаар 10.5 хувь, 2027 онд 8 хувь орчим гэж төсөөлсөн. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны барилгын өртгийн индексээр сургууль, цэцэрлэг зэрэг орон сууцны бус барилгын үнэ нэг жилд (2025 оны 1 дүгээр улирлаас 2026 оны 1 дүгээр улирал хүртэл) 11 хувь өссөн. Батлагдсан 2026 оны төслийн жагсаалтыг 2025 оны, 2027 оны төслийг 2026 оны 1 дүгээр улирлын үнээр тооцсон гэж үзэн энэ 11 хувиар ойролцоогоор тохируулахад ч ижил барилгын 2027 оны төсөвт өртөг 2026 оныхоос ойролцоогоор 40 хувиар өндөр хэвээр байна. Энэ нь инфляцын нөлөөг бүрэн тооцсон тохируулга бус, баримжаалсан тооцоо юм. Харьцуулсан төслүүдийн байршил, зураг төсөв, стандарт, ажлын хүрээ ялгаатай тул уг тооцоогоор өртгийн зөрүүгийн шалтгааныг тогтоох боломжгүй. Иймд үнийн өсөлт зөрүүг дангаараа тайлбарлахгүй бөгөөд шинэ стандарт, зураг төслийн үнэлгээ, материалын үнэ зэрэг шалтгааныг тодруулах шаардлагатай.

Өмнөх жилүүдэд эхэлсэн хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтад 320 суудалтай сургуулийн өртөг хэрэгжих явцдаа анхны тооцооноосоо медианаар 33 хувиар нэмэгдсэн байна. Жишээ нь 2019 онд эхэлсэн Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын 320 суудалтай сургуулийн барилгын өртөг анх 3.5 тэрбум төгрөг байсан бол 2025 оны жагсаалтад 4.66 тэрбум төгрөг болж 33 хувь өссөн.

2027 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮД БА ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ УЯЛДАА

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тухайн төрлийн барилга барих арга хэмжээ тусгагдаагүй 162 шинэ төслийн 100 нь (1.27 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй) Хөгжлийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн аль алинаас нь олдоогүй.

Хөрөнгө оруулалтын 318 шинэ төслийн 156 нь (2.99 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй) Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тухайн төрлийн барилга (жишээ нь сургууль) барих арга хэмжээ гэж тусгагдсан байна. Үлдсэн 162 төслийн (2.47 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй) хувьд тухайн төрлийн барилга барих арга хэмжээ төлөвлөгөөнд тусгагдаагүй тул төсөл бүрийг нэрээр нь Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө болон Засгийн газрын өргөн мэдүүлсэн 2026–2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслөөс нягтлав. Нэрээр нь хайхад олдоогүй төслүүд эдгээр баримт бичигт өөр нэрээр эсвэл ерөнхий арга хэмжээний хүрээнд туссан байж болно. Хөтөлбөрийн батлагдсан хавсралт цахим эх сурвалжаас олдоогүй тул өргөн мэдүүлсэн төслийг ашиглав.

Хүснэгт 5. 2027 оны төсөвт багтсан төслүүд Хөгжлийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан байдал

Хөгжлийн баримт бичигт туссан эсэх	Төслийн тоо	Өртөг, тэрбум төгрөг
Хөгжлийн төлөвлөгөөнд туссан	19	264.8
Зөвхөн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан	34	844.9
Хөгжлийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн аль алинаас нь нэрээр олдоогүй	100	1,265.7
Хоёр баримт бичигт нэрлэгдсэн эсэх нь баримтаас тодорхой бус	9	92.6
Нийт	162	2,467.9

Эх сурвалж: Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө (2 дугаар хавсралт), 2026–2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл, судлаачийн тооцоо

Хүснэгтэд үзүүлсэн ангилал тус бүрээс жишээ дурдвал, Хөгжлийн төлөвлөгөөнд туссан төсөлд Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн инженерийн дэд бүтэц, үерийн далан (52.8 тэрбум төгрөг), Увс аймгийн Улаангом сумын инженерийн шугам сүлжээ (37.8), Сэлэнгэ аймгийн Мандал сумын төвийн дулаан хангамж (32.9) орно. Зөвхөн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөлд “10 аймгийн дулааны станц” төслийн үргэлжлэл болох Төв (67.6), Өвөрхангай (66.4), Баянхонгор (65.5) аймгийн дулааны станцууд орно. Аль алинаас нь олдоогүй төсөлд “Ногоон, ухаалаг сургууль” төсөл (240.7), боловсролын салбарын сургалтын орчин, тоног төхөөрөмжийн төсөл (75.0), Улаанбаатар хотын Баянгол, Хан-Уул дүүргийн боловсролын хүртээмжийг сайжруулах төсөл (70.0) орно. Хөгжлийн баримт бичигт туссан арга хэмжээнд хамрагдах эсэх нь тодорхойгүй төсөлд Архангай аймгийн дулааны станцын гадна шугам сүлжээ (38.7), Зэвсэгт хүчний ангийн тусгай зориулалтын барилга (Хангайн бүс, 14.1), Хөвсгөл аймгийн Мөрөн сумын дулааны станцын дулаан дамжуулах төв, шугам (11.7) орно.

Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан 34 төслийн 25 нь (804.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй) төсвийн төсөлд туссанаас өөр дүн, хугацаа, санхүүжилтийн эх үүсвэр эсвэл ажлын үе шаттай тусгагджээ.

Үндэсний аудитын газар 2027 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтдээ хөтөлбөрийн үр дүнгийн түвшинд шалгаж, шинэ 318 төслийн 58 нь (993.8 тэрбум төгрөг, 18.2 хувь) хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй гэж үзсэн бөгөөд өмнөх жил энэ үзүүлэлт 12.1 хувь байжээ.

Үндэсний аудитын газраас ирүүлсэн жагсаалтаар тулгахад эдгээр 58 төслийн 23 нь энэхүү судалгаагаар Хөгжлийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн аль алинаас нь олдоогүй 100 төсөлд багтсан. Үлдсэн 35-ын 27 нь авто зам бөгөөд Хөгжлийн төлөвлөгөөнд авто зам барих арга хэмжээ тусгагдсан ч Үндэсний аудитын газар эдгээрийг хөтөлбөрийн үр дүнтэй уялдаагүй гэж үзжээ.


ШИНЭ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ, ДОТУУР БАЙРНЫ БАЙРШЛЫН НӨХЦӨЛ

Аймгийн төвөөс бусад суманд хэрэгжих шинэ 19 сургуулийн төслийн 9 нь нэг сургуульд ногдох сурагчийн тоо хамгийн өндөр сумдад, 3 нь хамгийн бага сумдад хэрэгжинэ.

Төслүүд тулгамдсан хэрэгцээтэй хэрхэн уялдаж байгааг үнэлэх зорилгоор өмнөх хэсэгт хөгжлийн төлөвлөгөөнд туссан байдлыг авч үзсэн бол энэ хэсэгт төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн нөхцөлийг шинжиллээ. Энэ нь хэрэгцээг шууд хэмжсэн дүгнэлт биш. Хэрэгцээг шууд үнэлэхэд шаардлагатай мэдээлэл уг судалгаанд бүрдээгүй тул сургууль, цэцэрлэг, дотуур байрны төслийг тухайн газрын одоогийн ачаалал (нэг байгууллагад ногдох хүүхэд) болон хүн амын мэдээлэлтэй харьцуулав.

Сургууль. Аймгийн төвөөс бусад суманд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан сургуулийн 19 төсөл байна (үүнд шинэ барилгаас гадна өргөтгөл, дуусгал, шинэчлэл орно). Улсын 309 сумыг нэг сургуульд ногдох суралцагчийн 2025 оны тоогоор эрэмбэлж, ачаалал хамгийн өндөр болон хамгийн бага дөрөвний нэг (25 хувь)-д багтах сумдыг ялгав. Шинэ сургуулийн 9 төсөл ачаалал хамгийн өндөр, 3 төсөл хамгийн бага сумдад хэрэгжихээр байна. Жишээ нь ачаалал хамгийн өндөр сумд буюу Төв аймгийн Жаргалант суманд (нэг сургуульд 1,529 суралцагчтай) 640 суудлын өргөтгөл хийгдэх ба Ховд аймгийн Булган суманд (1,191 суралцагчтай) 640 суудалтай, Сэлэнгэ аймгийн Баянгол суманд (1,005 суралцагчтай) 640 суудалтай сургууль шинээр баригдана. Харин ачаалал хамгийн бага сумдаас Завхан аймгийн Яруу суманд (93 суралцагчтай) 160 суудалтай, Дорнод аймгийн Гурванзагал суманд (179 суралцагчтай) спорт заал, номын сантай 160 суудалтай, Говь-Алтай аймгийн Шарга суманд (215 суралцагчтай) багшийн хөгжлийн төвтэй 320 суудалтай сургууль шинээр тус тус баригдана.

Зураг 8. Аймгийн төвөөс бусад сумын сургуулийн 19 төслийн 9 нь ачаалал хамгийн өндөр сумдад хэрэгжинэ




Эх сурвалж: УСХ, ерөнхий боловсролын сургууль ба суралцагчийн тоо (2025), Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Тайлбар: Өнгө нь сумыг аймгийн төвөөс бусад 309 сумын дунд нэг сургуульд ногдох суралцагчаар эрэмбэлэхэд аль дөрөвний нэгт орохыг заана.

Цэцэрлэг: Цэцэрлэгийн 20 төслийг аймгийн төвөөс бусад сум, аймгийн төвийн сум, нийслэлийн дүүрэг гэсэн байршлын төрлөөр тусад нь харьцуулсан. Байршлын төрөл бүрийн сум, дүүргийг нэг цэцэрлэгт ногдох хүүхдийн тоогоор эрэмбэлэхэд ачаалал хамгийн өндөр дөрөвний нэгд 6, хамгийн бага дөрөвний нэгд 8 төсөл хэрэгжинэ. Үлдсэн зургаан төсөл нь ачааллын түвшнээр дундах хоёр бүлэгт багтах сум, дүүрэгт хэрэгжинэ. Жишээ нь ачаалал хамгийн өндөр дөрөвний нэгт орох Өмнөговь аймгийн төв Даланзадгад суманд (нэг цэцэрлэгт 262 хүүхэдтэй) 200 ортой, Дорнод аймгийн Баян-Уул суманд (299 хүүхэдтэй) 100 ортой, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд (277 хүүхэдтэй) 200 ортой цэцэрлэг шинээр баригдана. Харин ачаалал хамгийн бага дөрөвний нэгт орох Сэлэнгэ аймгийн Шаамар суманд (79 хүүхэдтэй) 75 ортой, мөн аймгийн Орхон суманд (81 хүүхэдтэй) 150 ортой, Өмнөговь аймгийн Мандал-Овоо суманд (88 хүүхэдтэй) 150 ортой цэцэрлэг шинээр баригдана.

Зураг 9. Цэцэрлэгийн 20 төслийн 6 нь ачаалал хамгийн өндөр, 8 нь хамгийн бага сум, дүүрэгт хэрэгжинэ




Эх сурвалж: УСХ, цэцэрлэгийн тоо ба сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхэд (2025), Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Тайлбар: Өнгө нь сум, дүүргийг ижил төрлийн байршлын (аймгийн төвийн 21 сум, бусад 309 сум, нийслэлийн 9 дүүрэг) дунд нэг цэцэрлэгт ногдох хүүхдээр эрэмбэлэхэд аль дөрөвний нэгт орохыг заана.

Дотуур байр: УСХ-ны 2025 оны улсын дүнгээр дотуур байранд суух хүсэлт гаргасан хүүхэд 35,302, дотуур байранд амьдарч буй хүүхэд 34,177, зөрүү 1,125 байна. Хүсэлт гаргасан бүх хүүхдэд дотуур байр шаардлагатай хэвээр байгаа эсэх нь тодорхойгүй тул энэ зөрүү нь дотуур байр хүрэлцэхгүй байгаа хүүхдийн тоог бодитоор харуулахгүй. Өргөн мэдүүлсэн төсөвт 5,375 ор бүхий 24 дотуур байрны төсөл тусгасны 15 нь төрөлжсөн ахлах сургуулийн дотуур байр (жишээ нь Увс аймгийн Улаангом, Ховд аймгийн Жаргалант сумын олон улсын хөтөлбөртэй төрөлжсөн ахлах сургуулийн 300 ортой дотуур байр) тул эдгээрийн орны тоог 1,125-ын зөрүүтэй шууд харьцуулж, хүрэлцээний дүгнэлт хийх боломжгүй байв. Бусад есөн төсөл нь 50–160 ортой энгийн дотуур байр бөгөөд жишээ нь Архангай аймгийн Хайрхан (160 ор), Булган аймгийн Булган (110 ор), Өвөрхангай аймгийн Бат-Өлзий (100 ор), Булган аймгийн Хангал (50 ор) сумын дотуур байр орно. Аймгаар авч үзвэл хүсэлт гаргасан ба амьдарч буй хүүхдийн зөрүү 2025 онд Баян-Өлгий аймагт хамгийн их (463) байсан бөгөөд 2027 оны шинэ төсөлд тус аймагт дотуур байрны төсөл тусаагүй байна.

Зураг 10. Дотуур байранд суух хүсэлт гаргасан болон амьдарч буй хүүхдийн тооны зөрүү Баян-Өлгий аймагт хамгийн их байна (2025 он)




Эх сурвалж: YCX, дотуур байранд суух хүсэлт гаргасан болон амьдарч буй хүүхэд (2025), Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Тайлбар: Аймгийн нэрийн ард хаалтад 2027 оны төсөлд тусгасан энгийн дотуур байрны шинэ орыг харуулав. Төрөлжсөн ахлах сургуулийн 4,500 орыг оруулаагүй. Зөрүү нь дотуур байрны бодит хэрэгцээг шууд хэмжихгүй.

Нийслэл, аймгийн төвийн сургууль: Шинэ сургууль барихаар төлөвлөсөн нийслэлийн 5 дүүрэг, 3 аймгийн төвд 2025 онд нэг сургуульд 954–1,950 сурагч ногдож, улсын дундаж 911-ээс их байна. Эдгээр найман байршилд төслийн хүчин чадал буюу суудлын тоо заасан 320–960 суудалтай 11 сургуулийн төсөл (нийт суудлын тоо 8,320) тусгагдсан бөгөөд үүнээс нэг нь одоо байгаа сургуулийг буулгаж дахин барих төсөл байна. Одоо байгаа сургуулиудын суудлын тоо нээлттэй эх сурвалжаас олдоогүй тул шинэ суудал ачааллыг хэр бууруулахыг тооцоогүй. Мөн сум, дүүргээр ангийн тоо YCX-ны нээлттэй мэдээлэлд байхгүй тул нэг ангид ногдох сурагчийн тоог тооцоогүй болно.

Зураг 11. Шинэ сургууль баригдах нийслэлийн дүүрэг, аймгийн төвд нэг сургуульд 954–1,950 сурагч ногдож байна



Эх сурвалж: УСХ, ерөнхий боловсролын сургууль ба суралцагчийн тоо (2025), судлаачийн тооцоо

Эдгээр үзүүлэлт нь нутаг дэвсгэрийн нөхцөлийг тайлбарлах бөгөөд хүртээмж, барилгын нөхцөл болон үйлчлэх хүн ам хөрөнгө оруулалтын үндэслэл байж болох тул бага утга нь төсөл шаардлагагүйг харуулахгүй.

2027 ОНЫ БАРИЛГЫН ТӨСЛҮҮДИЙГ ӨМНӨХ ОНЫ ТЕНДЕРИЙН ҮНЭТЭЙ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН

Сургууль, цэцэрлэг, дотуур байрны таван бүлгийн 2027 оны 26 төслийн медиан төсөвт өртөг 2026 онд улсын төсвөөр санхүүжүүлэхээр зарласан ижил барилгын 25 тендерийн медиан төсвөөс 21–71 хувиар өндөр байна.

Ижил хүчин чадалтай 10 бүлгээс 2026 оны тендер, 2027 оны төсөл тус бүр гурваас доошгүй байгаа таван бүлгийг сонгов. Үүнд 320, 640 суудалтай сургууль, 100, 150 ортой цэцэрлэг, 100 ортой дотуур байр багтав. Сонгосон таван бүлгийн нийт 25 тендерийн төсвийг 2027 оны 26 төслийн төсөвт өртөгтэй харьцуулав. Медиан дүн гэдэг нь эрэмбэлсэн дүнгийн голын утга, тэгш тоотой бол голын хоёр дүнгийн дундаж юм. Жишээ нь 100 ортой цэцэрлэгийн медиан төсөв 2026 оны тендерт 3.6 тэрбум төгрөг, 2027 оны төсвийн төсөлд 4.6 тэрбум төгрөг буюу 28 хувиар өндөр байна. Тухайлбал, 2026 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг, Завхан аймгийн Эрдэнэхайрхан, Отгон, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын 100 ортой цэцэрлэгийн тендерийн төсөв 2.2–4.8 тэрбум төгрөг байсан бол 2027 оны төсвийн төсөлд ижил хүчин чадалтай цэцэрлэгийн өртөг 3.3–6.5 тэрбум төгрөгөөр тусжээ.

Хүснэгт 6. Монгол Улсын 2026 оны барилгын зарим төслийн тендерийн төсөв ба 2027 оны төслийн өртгийн харьцуулалт

Бүлэг	2026 оны тендер, медиан төсөв, тэрбум төгрөг	Тендерийн тоо	2027 оны төсөл, медиан өртөг, тэрбум төгрөг	Төслийн тоо	Зөрүү (хувиар)
Сургууль, 320 суудал	8.18	6	14.01	8	(+71%)
Цэцэрлэг, 150 ор	4.63	6	6.12	4	(+32%)
Цэцэрлэг, 100 ор	3.61	4	4.60	3	(+28%)
Сургууль, 640 суудал	17.73	5	21.61	7	(+22%)
Дотуур байр, 100 ор	4.01	4	4.86	4	(+21%)

Эх сурвалж: tender.gov.mn, opendatalab.mn, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Тендерийн зарласан төсөв нь тухайн худалдан авах ажиллагааны хамрах хүрээг илэрхийлдэг бөгөөд төслийн нийт төсөвт өртөгтэй заавал адил байх албагүй. Хугацаа, байршил, ажлын хүрээний ялгаа болон үнийн өөрчлөлтийг хасаж тооцоогүй тул энэ зөрүү нь өртөг хэтэрсэн, хэмнэлт гарсан, эсвэл барилгын үнэ өссөнийг дангаараа нотлохгүй.

Харьцуулалтад сонгосон тендерүүдийг 2026 оны улсын төсвийн жагсаалтын төсөлтэй нэр, байршил, хүчин чадлаар нь программын тусламжтай тулгаж холбосон. Жишээ нь Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын 100 ортой дотуур байр (тендерийн төсөв 4.4 тэрбум төгрөг), Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын 100 ортой цэцэрлэг (3.6 тэрбум төгрөг), Завхан аймгийн Улиастай сумын 150 ортой цэцэрлэг (4.8 тэрбум төгрөг), Говь-Алтай аймгийн Тонхил сумын 320 суудалтай сургууль (7.9 тэрбум төгрөг), Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 640 суудалтай сургуулийн (17.9 тэрбум төгрөг) тендерийг 2026 оны жагсаалтын ижил нэр, байршил, хүчин чадалтай төсөлтэй холбосон. Тооцоололд 25 тендер, 2027 оны 26 төсөл хамрагдсан. Эдгээр 25 тендерийн 10-ыг, үүнд бүлэг бүрийн медианыг тодорхойлсон бүх тендерийг tender.gov.mn-ийн албан ёсны мэдээлэлтэй тулгаж нягталсан. Үлдсэн 15-ын мэдээллийг opendatalab.mn-ээс авсан. opendatalab.mn нь төрийн худалдан авалтын зарлалыг түлхүүр үгээр хайх боломжтой тул ижил хүчин чадалтай барилгын тендерийг нэр, хүчин чадлаар нь хайж олоход ашиглав.


ЗАМЫН НЭГ КИЛОМЕТРИЙН ӨРТӨГ БА ОЛОН УЛСЫН ЖИШИГ

2027 оны төсвийн төсөлд туссан аймгийн төвийн болон бүсийн хоёр шинэ замын нэг километрийн өртөг (0.40, 1.03 тэрбум төгрөг) Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй, аймгийн төвүүдийг холбосон замынхаас (медиан 1.89 тэрбум төгрөг) бага байна.

Төслийн үе шат, үргэлжлэл, дуусгал, гүүр заагаагүй ба замын уртын мэдээлэл бүхий хатуу хучилттай таван шинэ зам 2027 оны төсвийн төсөлд тусжээ. Эдгээрийн нэг километрийн өртөг 0.40–1.51 тэрбум төгрөг бөгөөд Жаргалант – Шинэ-Идэр – Мөрөн чиглэлийн 151.5 км (1 км-ийн төсөвт өртөг 0.40 тэрбум төгрөг), Архангай аймгийн Эрдэнэбулган сумын төвийн их тойруу 27.9 км (1 км-ийн төсөвт өртөг 1.03 тэрбум төгрөг), Төв аймгийн Өндөрширээт сумын төв хүртэлх 27.2 км (1 км-ийн төсөвт өртөг 1.32 тэрбум төгрөг), Ховд – Улаангом чиглэлийн замаас Өмнөговь сум чиглэлийн 25.4 км (1 км-ийн төсөвт өртөг 1.51 тэрбум төгрөг), Увс аймгийн Түргэн суманд Улаангом – Хандгайт чиглэлийн замтай холбох 3.3 км (1 км-ийн төсөвт өртөг 0.97 тэрбум төгрөг) зам юм. Эдгээрээс 151.5 км замын өртөг бүтэн уртыг хамардаг эсэхийг Зам, тээврийн яамнаас тодруулга авах хүсэлт өгсөн байгаа тул түүнийг харьцуулалтад хадгалж, зураг дээр од (*) тэмдэгтэй, цайвар өнгийн баганаар ялгаж харуулав.

Харьцуулалтад Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилтээр баруун бүсэд хэрэгжиж буй замын төслийн (48186-008; Зээл нь 2023 оны 9 дүгээр сард батлагдаж, мөн оны 11 дүгээр сард хүчин төгөлдөр болсон) таван хэсгийн тооцоог ашиглав. Эдгээр тооцоог 2023 оны 1 дүгээр сарын үнээр хийсэн гэж үзэж, YCX-ны инженерийн барилга байгууламжийн өртгийн индексээр 2026 оны 1 дүгээр улирлын үнэд шилжүүлсэн (19 хувь): медиан 1.89, хамгийн бага нь 1.62 тэрбум төгрөг. АХБ-ны хэсгүүд нь аймгийн төвүүдийг холбосон, одоо байгаа замыг хатуу хучилттай болгох ажил тул тэдгээрийг 2027 оны төсөлд туссан аймгийн төвийн болон бүсийн хоёр замтай харьцуулав. Жаргалант – Шинэ-Идэр – Мөрөн чиглэлийн замын (0.40 тэрбум төгрөг) болон Архангай аймгийн Эрдэнэбулган сумын төвийн их тойруугийн (1.03 тэрбум төгрөг) нэг километрийн өртөг АХБ-ны төслийн хамгийн бага нэгж өртөгтэй хэсгийнхээс (1.62) бага бөгөөд үнийн тохируулга хийхгүй (АХБ-ны медиан 1.58) эсвэл АХБ-ны өөрийн үнийн өсөлтийн тооцоог (1.74) ашигласан ч мөн бага байна. Гэхдээ ийм зам хоёр л байгаа, 151.5 км замын өртөг бүтэн уртыг хамарсан эсэх тодорхойгүй, замын өргөн, хучилтын стандарт ялгаатай байж болох тул энэ харьцуулалт нь баримжаа төдий. Сумын чиглэлийн гурван замыг (Өндөрширээт, Өмнөговь, Түргэн) тусад нь авч үзэхэд нэг километрийн өртөг 0.97–1.51, медиан нь 1.32 тэрбум төгрөг бөгөөд энэ нь өмнөх жилүүдийн ижил уртын (3–30 км) замын медиан өртгийн хүрээнд (1.17–1.73 тэрбум төгрөг) байна.

Зураг 12. Аймгийн төвийн болон бүсийн шинэ хатуу хучилттай замын нэг километрийн өртөг, 2027 оны төсөл ба АХБ-ны жишиг (2026 оны үнээр, тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2); АХБ, 48186-008 төслийн удирдлагын гарын авлага; УСХ, барилгын өртгийн индекс; судлаачийн тооцоо

Тайлбар: 2027 оны төслийн өртгийг төсвийн төсөлд тусгасан дүнгээр (2026 оны 1 дүгээр улирлын үнээр тооцсон гэж үзэж) тохируулалгүй авсан; АХБ-ны 2023 оны тооцоог УСХ-ны индексээр 2026 оны 1 дүгээр улирлын үнэд шилжүүлсэн. Од (*) тэмдэгтэй, цайвар өнгийн баганаар төсөвт өртөг нь бүх 151.5 км-ийг хамарсан эсэх нь тодорхойгүй замыг харуулав. АХБ-ны таван хэсгийн медиан 1.89 тэрбум төгрөг. Сумын чиглэлийн гурван замыг текстэд тусад нь харьцуулав. АХБ-ны даваг тойрох 40 км замыг (цайвар саарал) уулын нөхцөлтэй тул медианд оруулаагүй. АХБ-ны эдгээр замын хэсэг 2027 оны төсвийн төслийн Хавсралт 2-т нэрээр олдоогүй бөгөөд энд зөвхөн жишиг болгон ашиглав.

Доорх хүснэгтэд 3–30 км урттай замуудын нэг километрийн медиан төсөвт өртгийг харьцуулав. 2027 оны үзүүлэлт 1.18 тэрбум төгрөг байгаа нь 2022, 2024 оны төсөвт туссан замуудын болон 2019, 2022, 2024 онд зарласан тендерүүдийнхээс бага, харин 2020 оны тендерүүдийнхтэй (1.17 тэрбум төгрөг) ойролцоо байна.

Хүснэгт 7. Шинэ хатуу хучилттай замын (3–30 км) нэг километрийн медиан өртөг, 2026 оны үнээр

Он	Төсвийн жагсаалт, эхэлсэн оноор (тэрбум төгрөг/км)	Замын тоо	Тендерийн төсөв, зарласан оноор (тэрбум төгрөг/км)	Тендерийн тоо
2019			1.43	14
2020			1.17	7
2022	1.73	9	1.43	7
2024	1.65	12	1.55	9
2027 (өргөн мэдүүлсэн)	1.18	4		

Эх сурвалж: Монгол Улсын 2022–2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, tender.gov.mn, УСХ, судлаачийн тооцоо

Тайлбар: Өмнөх оны төсвийн жагсаалт, тендерийн өртгийг УСХ-ны индексээр 2026 оны 1 дүгээр улирлын үнэд шилжүүлсэн; 2027 оны төслийг тохируулаагүй. Таваас цөөн замын төсөлтэй жилийн медиан нь цөөн төслийн өртгөөс ихээхэн хамаардаг тул ийм жилүүдийг өмнөх оны харьцуулалтаас хассан; 2027 оны дөрвөн замыг харьцуулах зорилгоор оруулав. Урт нь 30 км-ээс их тул 151.5 км замыг энэ харьцуулалтад оруулаагүй.

Энэ нь 2027 оны замын өртөг хэт бага, эсвэл хангалттай гэсэн дүгнэлт биш. Өртөгт зураг төсөл багтсан эсэх, замын ангилал, газар нутгийн нөхцөл тодорхойгүй. Мөн 2022 онд эхэлж одоо үргэлжилж буй зургаан замын өртөг хэрэгжих явцдаа анхны тооцооноосоо медианаар 60 хувь өссөн бөгөөд тухайн хугацааны барилгын үнийн өсөлт ойролцоогоор 43–74 хувь байжээ. Эдгээр нь Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км (114 тэрбум төгрөгөөс 185.5 тэрбум төгрөг болж 63 хувиар өссөн), Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4 км (115.9 тэрбум төгрөгөөс 182.6 тэрбум төгрөг, 58 хувь), Дорнод аймгийн Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх 50 км (49.8 тэрбум төгрөгөөс 84.9 тэрбум төгрөг, 70 хувь), Хэнтий аймгийн Норовлин сумаас Дорнод аймгийн Баян-Уул чиглэлийн 68.3 км (66.7 тэрбум төгрөгөөс 75.1 тэрбум төгрөг, 12 хувь), Говь-Алтай аймгийн төвийн 10 км (10 тэрбум төгрөгөөс 17.2 тэрбум төгрөг, 72 хувь), Архангай аймгийн Ихтамир, Чулуут сумын 65.8 км (39.5 тэрбум төгрөг, өөрчлөгдөөгүй) зам юм.

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨСЛҮҮД


2027 оны төсвийн төсөлд туссан аймгийн төвийн болон бүсийн хоёр шинэ замын нэг километрийн өртөг (0.40, 1.03 тэрбум төгрөг) Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй, аймгийн төвүүдийг холбосон замынхаас (медиан 1.89 тэрбум төгрөг) бага байна.

Тоног төхөөрөмжийн шинэ төслийн тоо цөөрч, нэг төслийн төсөвт өртөг өссөн бөгөөд 2027 оны 32 төслийн аль нь ч худалдан авах тоног төхөөрөмжийнхөө тоо ширхгийг заагаагүй байна.

Тоног төхөөрөмж гэдэгт машин, багаж, сервер, камер зэрэг зүйлс багтах юм. Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тоног төхөөрөмжийн 32 шинэ төсөл тусгагдсан. Тэдгээрийн төсөвт өртөг 356.7 тэрбум төгрөг буюу шинэ төслийн нийт өртгийн 6.5 хувь байна. Төсөвт өртгөөр хамгийн том гурван төсөл нь тоног төхөөрөмжийн шинэ төслүүдийн нийт төсөвт өртгийн 45 хувийг, хамгийн том долоон төсөл нь 78 хувийг эзэлж байна. Эдгээр нь боловсролын сургалтын орчин, тоног төхөөрөмжийн хүртээмжийн төсөл (75 тэрбум

төгрөг), эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тоног төхөөрөмж (50 тэрбум төгрөг), мөн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын (36.6 тэрбум төгрөг), батлан хамгаалах салбарын (32.6 тэрбум төгрөг), татварын мэдээллийн системийн (30.1 тэрбум төгрөг), Онцгой байдлын ерөнхий газрын (30.1 тэрбум төгрөг), төрийн байгууллагуудын (23.6 тэрбум төгрөг) тоног төхөөрөмж юм. Ихэнхийг "... салбарын тоног төхөөрөмж" гэж ерөнхий нэрлэсэн тул нэгж үнийг шалгах боломжгүй.

Зураг 13. Шинэ тоног төхөөрөмжийн төслүүдийн тухайн оны санхүүжилт (2022–2026 оны батлагдсан төсөв, 2027 оны өргөн мэдүүлсэн төсвийн төсөл)



Эх сурвалж: Монгол Улсын 2022–2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

Тайлбар: Жагсаалтад шинээр орсон тоног төхөөрөмжийн төслийн тоо 2024 онд хамгийн их буюу 213 байсан бол 2027 онд 32 болж цөөрсөн. Нэг төслийн медиан санхүүжилт 2022 онд 0.25 тэрбум төгрөг, 2024 онд 1.0 тэрбум төгрөг, 2025 онд 4.1 тэрбум төгрөг, 2026 онд 2.8 тэрбум төгрөг, 2027 онд 4.1 тэрбум төгрөг байна. Дөрвөн шинэ төсөлтэй 2023 оныг медианд оруулаагүй бөгөөд тэр оны 320.3 тэрбум төгрөгийн 85 хувь нь Улаанбаатарын нийтийн тээврийн автобусны нэг төсөлд ногдоно.

Тоног төхөөрөмжийн шинэ төслийн тоо 2024 онд 213 (нэг төслийн медиан 1.0 тэрбум төгрөг) байсан бол 2027 онд 32 (4.1 тэрбум төгрөг) болжээ. Нэг төслийн медиан дүн 2025 онд аль хэдийн 4.1 тэрбум төгрөг байсныг тэмдэглэх нь зүйтэй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДЛЫН МЭДЭЭЛЛИЙН БҮРЭН БАЙДАЛ

Шинэ 318 төслийн 201-д нь буюу 63 хувьд хүчин чадлыг суудал, ор, километр зэрэг хэмжих нэгжээр илэрхийлэн тусгаагүй тул төсөвт өртгийг нь ижил төрлийн бусад төслийнхтэй харьцуулах боломжгүй байна.

Ижил төрлийн төслийн өртгийг харьцуулахын тулд төслийн хүчин чадал (сургуулийн суудал, эмнэлэг болон дотуур байрны ор, замын урт (км), цахилгаан станцын чадал (МВт) гэх мэт) тусгагдсан байх шаардлагатай. Гэтэл шинэ 318 төслийн зөвхөн 117-д нь хүчин чадлыг тусгажээ. Хүчин чадлын мэдээлэлгүй 201 төсөлд тоног төхөөрөмжийн 32, ТЭЗҮ болон цахим системийн 4, их засварын 12, барилга байгууламжийн 153 төсөл (2.4 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй) тус тус орно. Жишээ нь "Ногоон, ухаалаг сургууль" төсөл (240.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй), Улаанбаатар хотын Баянгол, Хан-Уул дүүргийн боловсролын хүртээмжийг сайжруулах төсөл (70.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй), Ховд аймгийн Жаргалант сумын хүүхэд, залуучуудын спортын цогцолбор (70.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй), Дорноговь аймгийн Ханги хилийн боомтын шинэчлэл (63.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй), Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн инженерийн дэд бүтэц, үерийн далан (52.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй), Завхан аймгийн "Арцсуурь" хилийн боомтын шинэчлэл (51.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй), Хэнтий аймгийн Норовлин – Дадал чиглэлийн авто зам (49.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй) зэрэг төслийн нэрэнд хүчин чадал бичигдээгүй. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 14 МВт-ын дулааны станцын дулаан дамжуулах төв, 4.2 км гадна дулааны шугамын төсөлд чадал, урт хоёулаа бичигдсэн тул хүчин чадлын мэдээлэлтэй гэж тооцов. Гэхдээ нэг хэмжигдэхүүнээр бусад төсөлтэй харьцуулах боломжгүй.

Салбараар авч үзвэл ус, инженерийн шугам, үерийн хамгаалал (төслийн тоо 24; төсөвт өртөг 305.1 тэрбум төгрөг), хууль сахиулах, батлан хамгаалах, хил (төслийн тоо 12; төсөвт өртөг 182.7 тэрбум төгрөг), спорт (төслийн тоо 9; төсөвт өртөг 172.1 тэрбум төгрөг), төрийн захиргаа (төслийн тоо 12; төсөвт өртөг 119.8 тэрбум төгрөг), үйлдвэр, хөдөө аж ахуйн (төслийн тоо 9; төсөвт өртөг 110.0 тэрбум төгрөг) барилгын төслүүдийн алиных нь ч нэрэнд хүчин чадал бичигдээгүй. Барилга байгууламжийн төслүүдээс боловсролын салбарын 89 төслийн 67-д, эрчим хүчний 30 төслийн 13-т, зам тээврийн 48 төслийн 21-д хүчин чадлын мэдээлэл тусгагджээ.

Хүснэгт 8. Барилга байгууламжийн шинэ төслийн хүчин чадал туссан байдал, салбараар

Салбар	Нийт төслийн тоо	Хүчин чадал туссан төслийн тоо	Хүчин чадал тусаагүй төслийн тоо	Хүчин чадал тусаагүй төслийн өртөг, тэрбум төгрөг
Зам, тээвэр	48	21	27	623.1
Боловсрол	89	67	22	447.8
Ус, инженерийн шугам, үер, тохижилт	24	0	24	305.1
Эрчим хүч	30	13	17	228.7
Хууль сахиулах, батлан хамгаалах, хил	12	0	12	182.7
Спорт	9	0	9	172.1
Төрийн захиргаа, үйлчилгээ	12	0	12	119.8
Үйлдвэр, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, бусад эдийн засаг	9	0	9	110.0
Соёл	9	1	8	96.1
Нийгмийн хамгаалал, хүүхэд, ахмад	7	2	5	74.3
Эрүүл мэнд	14	6	8	30.8
Орон сууц	3	3	0	0.0
Нийт	266	113	153	2,390.5

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл (Хавсралт 2), судлаачийн тооцоо

2027 оны төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн хүчин чадалтай холбоотой дараах мэдээлэл тодорхой бус байгаа нь харагдлаа. Үүнд:

- Авто замын төслийн хувьд “эхлэл” гэж заасан нэг замын (А0201 замаас Төв аймгийн Бүрэн сум чиглэлийн 50 км авто замын эхлэл, 86.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй) урт нь замын нийт урт уу, эсвэл тухайн үе шатанд барих хэсгийн урт эсэх
- Замын урт заагаагүй, өртөг ихтэй 7 замын (Норовлин – Дадал; Бичигт боомтын төв замаас Дарьганга хүртэлх замын үргэлжлэл; Ховд – Улиастай чиглэлийн замын эхлэл; Толбо – Дэлүүн, 1 дүгээр үе шат; Нөмрөг – Улаангом замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх замын үргэлжлэл; Улаанбаатар – Мандалговь замаас Сэргэлэн сум хүртэлх замын эхлэл; Баянхонгор – Алтай замаас Чулуут сум хүртэлх зам, 2 дугаар үе шат; нийт 262.2 тэрбум төгрөг) нийт урт ба 2027 онд хэрэгжүүлэх хэсгийн урт
- Тоног төхөөрөмжийн хамгийн том 7 төслийн (Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд, Сангийн сайд, Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад тус бүр нэг) задаргаа, тоо хэмжээ, нэгж үнэ
- Олон аймгийг хамарсан төслүүдийн хувьд аль аймагт ямар хүчин чадал бүхий хэсэг ногдох талаарх мэдээлэл.с

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд туссан 5.45 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 318 шинэ төсөл, арга хэмжээнд дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- 2027 оны төсвийн төсөлд 318 шинэ төсөл, арга хэмжээнд 2027 онд 3.22 их наяд төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөжээ. Шинэ төслийн өртгийн 70 хувь нь боловсрол, зам тээвэр, эрчим хүчний салбарт, 23 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.
- “Оюу толгой” ХХК-ийн ногдол ашгаас санхүүжих 51 төсөл шинэ төслүүдийн 2027 оны санхүүжилтийн 61 хувийг эзэлнэ.
- Ижил төрөл, ижил хүчин чадалтай барилгын төсөвт өртөг 2.7 дахин хүртэл зөрүүтэй бөгөөд нэг төрлийн байршилд ч энэ зөрүү хадгалагдаж байна. Жишээ нь 640 суудалтай долоон сургуулийн өртөг 8.6-аас 23 тэрбум төгрөг хүртэл байна.
- Төсвийн тухай хуулийн 29.3.5 дахь заалт буюу шинээр эхлэх барилга байгууламжийн эхний жилийн санхүүжилт нь төсөвт өртгийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваасан хэмжээнээс багагүй байх шаардлагад хамаарах улсын төсвөөр санхүүжих барилга байгууламжийн 218 төслийг шалгахад 38 нь шаардлага хангасан бол 180 нь хангаагүй байна. Бусад 100 төсөлд (тоног төхөөрөмж, их засвар, ТЭЗҮ, цахим систем, “Оюу толгой” ХХК-ийн ногдол ашгаас санхүүжих барилга байгууламж) заалт хамаарах эсэх тодорхойгүй тул хуулийн дүгнэлт гаргаагүй.
- Хоёр ба түүнээс дээш жил хэрэгжих 207 төслийн 196-д 2027 онд тэнцүү хуваасан хэмжээнээс бага санхүүжилт тусгажээ.
- Ижил барилгын 2027 оны төсөвт өртөг 2026 оны батлагдсан жагсаалтынхаас ойролцоогоор 55 хувиар, барилгын үнийн нэг жилийн өсөлтөөр (11 хувь) тохируулахад ч ойролцоогоор 40 хувиар өндөр байна. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны таван бүлгийн 26 төслийн медиан өртөг 2026 онд зарласан 25 тендерийн медиан төсөвөөс 21–71 хувиар өндөр байна.
- Шинэ 318 төслийн 156 нь Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тухайн төрлийн барилга барих арга хэмжээ гэж тусгагдсан. Үлдсэн 162 төслийн 19 нь Хөгжлийн төлөвлөгөөнд, 34 нь зөвхөн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт олдсон, 100 нь (1.27 их наяд төгрөг) аль алинаас нь олдоогүй. Үлдсэн есөн төсөлтэй холбогдох арга хэмжээ хөгжлийн баримт бичгүүдэд олдсон боловч тэдгээр нь эдгээр төслийг хамарч буй эсэхийг тогтоох боломжгүй байв. Жишээ нь Архангай, Хөвсгөл аймгийн дулааны шугамын төслүүд “10 аймгийн дулааны станц” арга хэмжээнд багтах эсэх тодорхойгүй.
- Аймгийн төвөөс бусад суманд хэрэгжих шинэ 19 сургуулийн төслийн 9 нь сургуулийн ачаалал хамгийн өндөр сумдад, 3 нь хамгийн бага сумдад хэрэгжинэ.
- Аймгийн төвийн болон бүсийн хоёр шинэ замын нэг километрийн өртөг (0.40, 1.03 тэрбум төгрөг) АХБ-ны аймгийн төвүүдийг холбосон замынхаас (медиан 1.89) бага, 151.5 км замыг хасаж ижил уртын (3–30 км) дөрвөн замаар харьцуулахад ч (медиан 1.18) өмнөх жилүүдийн төсвийн жагсаалтын медианаас бага байгаа тул өртөгт ямар ажил багтсаныг тодруулах шаардлагатай. Сумын чиглэлийн гурван замын нэг километрийн өртгийн медиан 1.32 тэрбум төгрөг байна.
- Тоног төхөөрөмжийн 32 шинэ төслийн (356.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй) аль нь ч худалдан авах зүйлийнхээ тоо ширхгийг заагаагүй тул нэгж үнийг шалгах боломжгүй байв.
- Шинэ 318 төслийн 201-ийн буюу 63 хувийнх нь хүчин чадал тусаагүй байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төслүүдийн хүчин чадлын мэдээллийг ил болгох.
- Төслүүдийн эхний жилийн санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 29.3.5 дахь заалтын шаардлагад нийцүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөл, Хавсралт 2, УБ., 2026, https://lawforum.parliament.mn/files/17949/?d=1
2. Үндэсний аудитын газар, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлт, УБ., 2026, https://lawforum.parliament.mn/files/18006/?d=1
3. Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, УБ., 2026, https://lawforum.parliament.mn/files/17944/?d=1
4. Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн товч танилцуулга, УБ., 2026, https://lawforum.parliament.mn/files/17945/?d=1
5. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, УБ., 2025 (2022–2025 оны мөн хавсралтыг харьцуулалтад ашигласан), https://legalinfo.mn/storage/uploads/process/202512/file_1764641819131703_15941724180424050.docx
6. Төсвийн тухай хууль (legalinfo.mn, нэгтгэсэн эх, 2026 оны 9 дүгээр сарын 29-нд татсан), https://legalinfo.mn/mn/detail/12254
